**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ**
**ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 16 өдөр Дугаар А/28 Улаанбаатар хот

Авилгын эсрэг 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Авилгын эсрэг хуулийн 5, 6 дугаар зүйл, "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалт, Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 03/3109 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн засаг даргын 2022 оны А/147 дугаар захирамжаар батлагдсан "Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө" болон Институтийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлж боловсруулсан "Авилгын эсрэг 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Энэ төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, биелэлтэд байнгын хяналт тавьж, үр дүнгийн эхний хагас жил, жилийн эцсийн тайланг Нийслэлийн засаг даргын тамгын газарт тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

3. Энэ төлөвлөгөөний биелэлтийг хангуулахад шаардагдах 800,000 (найман зуун мянга) төгрөгийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу, Институтийн 2022 оны үйл ажиллагааны бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д даалгасугай.

ДАРГА С.ОЧИР-ЭРДЭНЭ

ТУ31925 9020010718 5369568

3150600207

“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/08 тушаалын хавсралт ...

ТУЗ1925 9020010718 5369568

# ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ-ЫН 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хариуцах байгууллага, хэлтэс, албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг. Шударга, хариуцлагатай ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авилгын эрсдлээс урьдчилан сэргийлэх, албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | |
| 1 | 4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилно. | Жилдээ | - | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна. | Хуулийн зөвлөх, ЭБАТ |
| 2 | | Байгууллагын бүтцийн дагуу шинээр бий болох удирдах албан тушаалын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулна. | Жилдээ | - | - | Шинээр томилогдох удирдах албан тушаалын ажлын байранд тавигдах нийтлэг шаардлагыг баталж, мөрдүүлнэ. | Хуулийн зөвлөх, ЭБАТ |
| 3 | 4.1.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий шалгуурыг үндэслэн дэвшүүлж, томилон ажиллуулна. | Жилдээ | - | - | Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан иргэнийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилсон байна. | ЗУСХ, Хуулийн зөвлөх, ЭБАТ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | 4.1.1.3.олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох | Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын хэрэгжилтийг хангана. | Жилдээ | - | - | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэн зөв, шударгаар үнэлсэн байна. | Удирдлагын баг, ЗУСХ, Хуулийн зөвлөх, ЭБАТ |
| 5 | 4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | Албан тушаалтанд холбогдох авилга, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг мэдээллийн олон эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэнэ. | Жилдээ | - | - | Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн зөвлөл, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байна. | Ёс зүйн зөвлөл, Хуулийн зөвлөх, ЭБАТ |
| Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, албан хаагчийн хариуцлагыг дээшлүүрэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | |
| 6 | 4.1.2.6.өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлэх үйлчилгээг цахимжуулна. | Жилдээ | - | - | Зуслангийн газартай холбоотой иргэдийн иргүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг мэдээлэл, тодруулга зэргийг цахимаар авах боломж бүрдүүлсэн байна. | Удирдлагын баг, Нийслэлийн цахим хөгжил, мэдээллийн технологийн газартай хамтран |
| 7 | | Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх UB ERP системийн өргөдөл, гомдлын дэд цэс ашиглах сургалтад холбогдох ажилтныг хамруулна. | Жилдээ | - | - | | Удирдлагын баг, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр | | | | | | | |
| 8 | 4.1.3.1.улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх | Гадаадын зээл, тусламж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулна. | Жилдээ | - | - | Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, хэрэгжүүлсэн байна. | Удирдлагын баг, ЗУСХ |
| 9 | | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд худалдан авалт болон бусад ил тод байлгах мэдээллийг тайлагнаж байна. | Жилдээ | - | - | Мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг тухай бүр хэрэгжүүлж хэвшсэн байна. | ЗУСХ |
| 10 | 4.1.3.6.нийтийн албаны санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох | ISO 9001:2015- Чанарын менежментийн тогтолцооны сургалтыг зохион байгуулж, ISO9000 бүлэг стандартын ISO 10013 стандартын дагуу дотоод аудитор бэлтгэх сургалтад холбогдох ажилтнуудыг хамруулж, дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог бий болгоно. | Жилдээ | - | - | Дотоод аудит, хяналт шалгалтыг хийх журам боловсруулан батлуулж, дүгнэлт, зөвлөмж өгсөн байна. Хяналт, шалгалтын үр дүнд буюу гүйцэтгэлийн үнэлгээний дагуу сайжруулалт хийгдэж байгаа эсэхийг хянах тогтолцоог бий болгосон байна. | ЕТХМХ, ЗУСХ, Дотоод аудитын баг |
| 11 | 4.1.3.7.аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах | Удирдлага, санхүү хариуцсан албан хаагчдад төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр сургалтад хамрагдана. | Жилдээ | - | - | Холбогдох албан тушаалтнууд төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр сургалтад хамрагдаж, мэдлэг чадвар эзэмшинэ. | Удирдлагын баг, ЗУСХ |
| Дөрөв. Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх Худалдан авах ажиллагааны үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | |
| 12 | 4.1.4.1.тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх | Худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулах, | 4 дүгээр улирал | Өөрийн эх | 330,517,045 | Худалдан авах ажиллагааны мэдээлэл нээлттэй болж, иргэд | Удирдлагын баг, ЗУСХ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | холбогдох байгууллагад хүргүүлэх, олон нийтэд ил тод мэдээлэх | | үүсвэр | | хяналт тавих боломж нөхцөл бүрдсэн байна. | |
| 13 | | Худалдан авах ажиллагаанд ил тод өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явцын мэдээллийг нээлттэй, шууд татан авч үзэх боломжтой байдлаар байршуулна. | Тухай бүр | - | - | Мэдээллийн ил тод байдлыг хангасан байна. | Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, ЗУСХ, Маркетинг, менежментийн хэлтэс |
| Тав. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | |
| 14 | 4.1.7.3.төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх | Байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлнэ. | Жилдээ | - | - | Хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна. | ЗУСХ, ЭБАТ |
| Зургаа. Авилгын эсрэг хууль тогтоомжийг ажилтнуудад сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр | | | | | | | |
| 15 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэд, ажилтан, албан хаагч нарт сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага, зэргийг албан ёсны цахим хуудас, мэдээллийн | Жилдээ | - | - | Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байна. | ЗУСХ, ЭБАТ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | самбарт байршуулна. | | | | | |
| 16 | | Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын онцлогт тохируулан зохион байгуулна. | Жилдээ | - | - | Аливаа аян, арга хэмжээг байгууллагын онцлогт тохируулан зохион байгуулж, ажилласан байна. | ЗУСХ, ЭБАТ |
| 17 | | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар шинээр ажиллуулна. | Жилдээ | Өөрийн эх үүсвэр | 800,000 | Мэдээллийг тогтмол шинэчлэж хэвшсэн, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдээллийг ил тод байршуулсан байна. | ЗУСХ, ЭБАТ |
| 18 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах | Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-аас тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна. | Жилдээ | - | - | Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байна. | ЗУСХ, ЭБАТ |
| 19 | | АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байна. | Жилдээ | - | - | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоогоор хэмжигдэнэ. | ЗУСХ,ЭБАТ |
| 20 | АТГ-аас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж;<br>Мөрдөгчийн мэдээлэл;<br>Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ;<br>Холбогдох ХАСХОМ-ын тайлан мэдээг тогтоосон хугацаанд мэдээлсэн байна. | Жилдээ | - | - | Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.<br>ХАСХОМ-ын тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь хүргүүлсэн байна. | ЗУСХ, ЭБАТ |
| 21 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдсэн байна. | Жилдээ | - | - | Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна. | ЗУСХ, ЭБАТ |
| | | - Хувийн хэвшилтэй байгуулах аливаа гэрээ | | | | Холбогдох байгууллагын санал, санаачилга, уриа, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байна;<br>- Хувийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тухай бүр бөглүүлсэн байна. | Жилдээ | - | - | аянд нэгдсэн байх;<br>Хувийн хэвшилтэй байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байх.<br>Хувийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл бөглүүлсэн байна | ЗУСХ, ЭБАТ |
| 22 | Авлига, ашиг сонирхлын зөрчил, үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ г.м/ | Жилдээ | - | - | Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байна. | ЗУСХ, ЭБАТ |
| 23 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах | Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4;<br>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах; | Жилдээ | - | - | Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэсэн байна. | ЗУСХ, ЭБАТ |